




ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАНИЛЦУУЛАХ СУДАЛГАА



СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС
2018



Агуулга

ОРШИЛ.....	2
ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ.....	3
НЭГ. Малчдын тоо тэдний соёл ахуйн үзүүлэлт.....	6
I.1 Малчдын тоо, насны бүтэц.....	6
I.1.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлт.....	7
ХОЁР. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн.....	8
II.1. Малын тоо бүтэц.....	8
II.2 Хувийн /амины/ малын тоо бүтэц.....	13
II.3 Малтай өрхийн малын бүлэглэлт.....	13
II.4. Хээлтэгч мал.....	14
II.5 Төл бойжилт.....	16
II.6 Том малын зүй бусын хорогдол.....	16
II.7 Малын хээл хаялт, сувайралт.....	17
II.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	18
II.9 Малын хэрэглээний зарлага.....	19
II.10 Сүргийн бүтэц.....	21
ГУРАВ. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	
III.1 Бэлчээрийн хүрэлцээ.....	22
III.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт.....	23
III.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж.....	24
ДҮГНЭЛТ.....	25

Оршил

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар өнөөг хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн бөгөөд цаашид ч мөн уул уурхайн салбарыг даган эрчимтэй хөгжүүлэх бодлого чиглэлийг баримталж байна.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээл, худаг усны тооллогыг 2017 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж явууллаа.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

Судалгааны зорилго: Аймгийн эдийн засагт Хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Судалгааны агуулга: Энэ зорилгоор мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амжиргааны талаар бодлого, малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодорхойлох, газар тариалангийн салбарын хувьд тариалалт, ургац хураалт, ургацын хэмжээг тооцож, аймгийн дүнд эзлэх хувийг тогтоов.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Бог-д шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ	- 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу	- 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр	- 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал	- тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ-Өмнөх оны төл,	2, 3 настай
Адуу-	Өмнөх оны төл, 2 настай
Үхэр-	Өмнөх оны төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдолд: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	-	0.45
Таримал тэжээл	-	0.35
Даршны ургамал	-	0.25
Гар тэжээл, хужир шүү	-	1.00
Төмс ногооны хаягдал	-	0.22
Үр тарианы хаягдал	-	0.90
Лай	-	0.40
Сүрэл	-	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай: Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай: Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай: Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац: Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац: Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

1. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН БАЙДАЛ

1.1. Малчдын тоо, насны бүтэц:

хүснэгт 1

Өрх, малчдын тоо насны бүтэц

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
											хувь	зөрүү
Малтай өрх	7579	7638	6894	6661	6619	6713	6771	6963	7172	7418	103.4	246
Малчин өрх	6408	6301	5628	5431	5131	5173	5216	5417	5647	5819	103	172
Малчдын тоо	11926	11612	10258	9751	9279	9226	9449	9588	9846	9635	97.9	-211
Үүнээс: 16-34 насны	6049	5614	4640	4154	3695	3534	3493	3473	3408	3084	90.5	-324
35-аас тэтгэвэрт	4433	4677	4388	4366	4544	4706	4944	5135	5353	5079	94.9	-274
гарах хүртэл насны												
Тэтгэврийн насны	1444	1321	1230	1231	1040	986	1012	980	1085	1431	131.9	346
Бусад										41	0	-41
Нийт малчдаас эмэгтэй	5649	5453	4809	4598	4403	4382	4408	4378	4503	4315	95.8	-188
Насны бүрэлдэхүүн %	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	0
Үүнээс: 16-34 насны	50.7	48.3	45.2	42.6	39.8	38.3	37	36.2	34.6	32.0	92.5	-3
35-аастэтгэвэрт	37.2	40.3	42.8	44.8	49	51	52.3	53.6	54.4	52.7	96.9	-2
гарах хүртэл насны												0
Тэтгэврийн насны	12.1	11.4	12	12.6	11.2	10.7	10.7	10.2	11	14.9	135	4
Бусад										0.4	0	-
Нийт малчдаас эмэгтэй %	47.4	47	46.9	47.2	47.5	47.5	46.7	45.7	45.7	44.8	98	-1
Нэг малчин өрхөд ногдох	263	278	180	225	276	320	354	379	409	456	111.5	47
малын тоо /толгойгоор/												

Эх сурвалж: 2008-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2017 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7418 малтай өрх, үүнээс 5819 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 34.8 хувийг малтай өрх эзэлж байна.

2017 онд мал аж ахуйн салбарт 9635 малчид ажиллаж байна. Нийт малчдын 44.8 хувь нь буюу 4315 эмэгтэйчүүд байна.


Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 3.0 хувиар буюу 172 өрхөөр өссөн, малчдын тоо өмнөх оноос 2.1 хувиар буюу 211 малчнаар буурсан үзүүлэлт харагдаж байна.

Нийт малчин өрхийн 32.0 хувийг 16-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд, 52.7 хувийг 35-аас 59 насны хүмүүс харин үлдсэн 14.9 хувийг тэтгэврийн өндөр настай хүмүүс эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад 16-34 насны залуучууд, 35-59 насны хүмүүс мал аж ахуй эрхлэх нь буурч, тэтгэврийн насны хүмүүс мал аж ахуй эрхлэх нь ихэссэн үзүүлэлт харагдаж байна.

2017 онд нэг малчин өрхөд 456 толгой мал оногдож байгаа нь өмнөх оноос 47 толгой малаар өссөн байна.

Зураг 1

МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮТЭЦ



1.2. Малчдын соёл ахуйн үзүүлэлт .

2017 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 78.3 хувь буюу 4559 өрх цахилгааны эх үүсвэртэй, 74.2 хувь буюу 4318 өрх телевизортой, 47.9 хувь буюу 2788 өрх автомашинтай, 49.7 хувь буюу 2892 өрх мотоциклтой, 0.2 хувь буюу 14 өрх трактортой байна.

Өмнөх онтой харьцуулахад цахилгааны эх үүсвэртэй өрх 55 өрхөөр буюу 1.2 хувиар буурсан, телевизортой өрх 4.6 хувиар, автомашинтай өрх 13.8 хувиар, мотоциклтой өрх 9.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Малчдын соёл ахуйн үзүүлэлт


хүснэгт 2

	Өрхийн тоо							Малчин өрхийн тоонд эзлэх хувь						
	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Цахилгааны эх үүсвэртэй	5090	3940	5317	4607	4654	4614	4559	93.7	76.8	103	88.3	85.9	82.4	78.3
Телевизортой	4409	3841	4142	4251	4267	4126	4318	81.2	74.9	80.1	81.5	78.8	75.6	74.2
Автомашинтай	2196	2405	2295	2412	2581	2449	2788	40.4	46.9	44.4	46.2	47.6	45.7	47.9
Мотоциклтой	3642	2792	2597	2705	2624	2638	2892	67.1	54.4	50.2	51.9	48.4	46.5	49.7
Трактортой	31	17	28	21	23	24	14	0.6	0.3	0.5	0.4	0.4	0.4	0.2

Эх сурвалж: 2010- 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малчдын соёл ахуйн үзүүлэлт /2012-2016/

Зураг 2



2. МАЛ АЖ АХУЙН ТОО, БҮТЭЦ

2.1. Малын тоо.

2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 58 багт 2.6 сая толгой мал тоолуулж 2016 оныхоос 340.4 мянган толгой малаар буюу 14.7 хувиар өссөн байна. Мал сүрэг таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна.


Тооллогын дүнгээр тэмээний тоо 141232 толгой, адуу 98651 толгой, үхэр 26997 толгой, хонь 613980 толгойд, ямаа 1773528 толгойд хүрсэн байна. Өмнөх оныхоос тэмээ 10739 толгойгоор буюу 8.2 хувиар, адуу 13353 толгойгоор 15.7 хувиар, үхэр 4848 толгойгоор буюу 21.9 хувиар, хонь 93075 толгойгоор 17.9 хувиар, ямаа 218410 толгойгоор буюу 14.0 хувиар тус тус өссөн байна.

	Малын тоо /төрлөөр/								2017/2016	
	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Хувь	Зөрүү
Бодоор*	289845	330021	376964	425661	474842	519869	584394	661517	113.2	77123
Толгойн тоо	1010327	1223459	1419253	1653264	1849043	2055765	2313963	2654388	114.7	340425
Тэмээ	83765	87837	97317	103120	112741	118584	130493	141232	108.2	10739
Адуу	37621	43366	50100	58164	66345	74170	85298	98651	115.7	13353
Үхэр	7532	8732	10762	13374	16085	18653	22149	26997	121.9	4848
Хонь	212841	257444	299816	350811	397600	447008	520905	613980	117.9	93075
Ямаа	668568	826080	961258	1127795	1256272	1397350	1555118	1773528	114.0	218410

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов.
Эх сурвалж: 2009-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зураг 3

Малын өсөлтийн хувь /2017/



Зураг 3 - Нийт мал сүргийн өсөлтийн 67 хувийг ямаа, 23 хувийг хонь, 5 хувийг тэмээ, 4 хувийг адуу, үлдсэн 1 хувийг үхэр сүргийн өсөлт эзэлж байна.

Малын тоо / сумдаар/

Сумын нэр	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016
Баяндалай	124361	138201	153575	168829	180270	190396	105.6
Баян-Овоо	75368	89577	96465	107805	124227	147595	118.8
Булган	87519	110534	131464	142671	165837	194503	117.3
Гурвантэс	126318	143640	140895	166228	181562	205078	113.0
Мандал-Овоо	74118	93002	116590	135139	157716	185166	117.4
Манлай	102618	117787	128835	133820	160576	188781	117.6
Номгон	172465	197239	216984	244795	262296	289869	110.5
Ноён	81593	92895	105200	116669	119638	126694	105.9
Сэврэй	104662	119881	130386	147538	156286	177238	113.4
Ханбогд	123291	126003	126467	133013	151446	172774	114.1
Ханхонгор	103148	127966	156261	174303	204635	242353	118.4
Хүрмэн	91297	106674	121208	137961	145908	159572	109.4
Цогт-Овоо	50690	61866	73695	85766	105999	131945	124.5
Цогтцэций	53312	65741	75156	82429	102660	130758	127.4
Даланзадгад	48493	62258	75862	78799	94907	111666	117.7
Дүн	1419253	1653264	1849043	2055765	2313963	2654388	114.7

Эх сурвалж: 2012-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт мал сүрэг өмнөх онтой харьцуулахад 5.6-27.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт мал сүрэг өмнөх мөн үеэс 14.7 хувиар өсчээ.

Зураг 4

Малын тоо /сумдаар/



Аймгийн дундаж малын тоо 176959 толгой болж малын тоогоор 8 сум аймгийн дунджаас дээгүүр, 7 сум дунджаас доогуур байна.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн хүчин зүйл


/мян.толгой/	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	хүснэгт 5	
									2017/2016	Хувь
Бойжуулсан төл	56468	406786	393591	469222	450151	530744	540484	664257	122.9	123773
100 эхээс бойжуулсан төл / толгойгоор /	8	78	82	82	68.1	68.4	64	69	107.8	5
Хээлтэгч малын тоо	521692	477428	575182	660840	776420	845476	963150	1066064	110.7	102914
Том малын зүй бус хорогдол	618766	9399	8815	9727	11128	17326	10089	11251	111.5	1162
Хээл хаясан хээлтэгч	12755	1904	978	846	2241	2304	5370	2306	42.9	-3064
Сувайрсан хээлтэгч	394952	95400	79705	93158	183799	206988	278868	276346	99.1	-2522

Эх сурвалж: 2009-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малын өсөлтөнд нөлөөлдөг гол хүчин зүйл болох бойжсон төлийн тоо өмнөх оноос 123.7 мянган төлөөр өсч , том малын зүй бусын хорогдол өмнөх оноос 1162 малаар буюу 11.5 хувиар , хээлтэгч малын тоо 10.7 хувиар өссөн, сувайрсан хээлтэгч өмнөх оноос 57.1 хувиар, хээл хаясан хээлтэгч 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 5

Бойжуулсан төл /мян.толгой/



2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр бойжуулсан төл 664.3 мянгад хүрсэн нь өмнөх оны мал тооллогын дүнгээс 123.8 мянган төлөөр буюу 22.9 хувиар буурсан өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

Зураг 6

Хээлтэгч малын тоо



Хээлтэгч малын тоо нь 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1066.1 мянгад хүрсэн нь өмнөх мөн үеэс 102.9 мянгаар буюу 10.7 хувиар өссөн байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

хүснэгт 6

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	6.2	5.4	4.8	4.9	8.3	7.2	6.9	6.2	6.1	5.8	5.6	5.3
Адуу	3.7	3.3	3.1	3.1	3.7	3.5	3.5	3.5	3.6	3.6	3.7	3.7
Үхэр	0.8	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.8	0.8	0.9	0.9	1	1.0
Хонь	21.8	21.2	20.8	21.4	21.1	21	21.1	21.2	21.5	21.7	22.5	23.1
Ямаа	67.6	69.4	70.5	69.9	66.2	67.5	67.7	68.2	67.9	68	67.2	66.8


Эх сурвалж: 2006-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл өмнөх оноос хонин сүрэг 0.6 хувиар өсч , ямаан сүрэг 0.4 хувиар, тэмээн сүрэг 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бог малын дотор хонин сүргийн эзлэх хувь нь 23.0, ямаан сүрэг 67.0 хувийг тус тус эзэлж байгаа нь уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн алдагдаж байгааг илэрхийлж байна.

зураг 7

Мал сүргийн бүтэц /2017/



Манай аймгийн хувьд нийт сүрэгт эзлэх ямааны хувь улсдаа хамгийн өндөр байгаа нь мал сүргийн бүтцэд зохисгүй өөрчлөлт гарч байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжилвэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд муугаар нөлөөлөх нь тодорхой байна.

2.2 . Хувийн / амины / малын тоо:

2017 онд хувийн малын тоо 2642.4 мянган толгойд хүрч, нийт малын 99.6 хувийг эзэлж байна. Тэмээн сүргийн 99.3 хувь, адуун сүргийн 99.8 хувь, үхэр сүргийн 99.5 хувь, хонин сүргийн 99.4 хувь, ямаан сүргийн 99.6 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо өмнөх оноос 341.5 мянган толгой буюу 14.9 хувиар өссөн байна.

Хувийн малтай өрх, малын тоо / төрлөөр/

Он	Малтай өрхийн тоо мян.өрх	Бүгд	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2003	7.4	892.4	69.6	36.6	5.9	199.7	580.6
2004	7.3	1054.1	70.2	40.7	7.3	227.6	708.3
2005	7.3	1105.9	70.3	42.6	8.5	243.4	741.1
2006	7.2	1140.3	70.7	42.1	8.6	249.2	769.7
2007	7.3	1383.8	74.6	46.3	10	293.4	959.5
2008	7.6	1666.1	80	53	12.3	347.2	1173.6
2009	7.6	1738.5	84.9	53.6	12.9	371.7	1215.3
2010	6.9	1002.2	83.2	37.6	7.5	210.4	663.6
2011	6.7	1216.7	87.5	43.4	8.7	255.4	821.8
2012	6.6	1409.2	96.6	50.1	10.7	296.8	954.9
2013	6.6	1642.1	102.4	58.2	13.3	347.4	1120.9
2014	6.7	1837.8	111.9	66.3	15.9	394.1	1249.4
2015	6.9	2043.4	117.8	74.2	18.5	443	1389.9
2016	7.1	2300.9	129.6	85.2	22	516.7	1547.4
2017	7.4	2642.4	140.2	98.5	26.9	610.3	1766.5

Эх сурвалж: 2003-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2017 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 66.9 хувийг ямаа, 23.1 хувийг хонь, 5.3 хувийг тэмээ, 3.7 хувийг адуу, 1.0 хувийг үхэр эзэлж байна.

2.3 Малтай өрхийн малын бүлэглэлт.

	Малтай өрхийн тоо			Нийт өрхөд эзлэх хувь			Малын тоо /мян.толгой/		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
Бүгд	6963	7172	7418	100	100	100	2043.4	2 302	2643
10 хүртэл малтай	140	105	87	2.01	1.46	1.2	1	1	1
11-30 малтай	468	445	400	6.72	6.2	5.4	9.8	9	8
31-50 малтай	510	469	451	7.32	6.54	6.1	20.9	19	19
51-100 малтай	944	983	953	13.56	13.71	12.8	69.3	72	70
101-200 малтай	1299	1271	1207	18.66	17.72	16.3	191.8	189	177
201-500 малтай	2338	2343	2399	33.58	32.67	32.3	771	778	798
501-999 малтай	970	1179	1419	13.93	16.44	19.1	636	781	961
1000-1499 малтай	269	337	447	3.86	4.7	6.0	299.9	380	508
1500-2000 малтай	20	31	40	0.29	0.43	0.5	32.8	51	67
2001-ээс дээш малтай	5	9	15	0.07	0.13	0.2	11	20	33

Эх сурвалж: 2015-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт өрхийн 1.2 хувийг 10 хүртэл малтай өрх, 5.4 хувийг 11-30 малтай өрх, 6.1 хувийг 31-50 малтай өрх, 12.8 хувийг 51-100 малтай өрх, 16.3 хувийг 101-200 малтай өрх, 32.3 хувийг 201-500 малтай өрх, 19.1 хувийг 501-999 малтай өрх, 6.0 хувийг 1000-1499 малтай өрх, 0.5 хувийг 1500-2000 малтай өрх, үлдсэн 0.2 хувийг 2000 –с дээш малтай өрх эзэлж байна. 1000 ба түүнээс дээш малтай 501 өрх тоологдсон нь өнгөрсөн оноос 125 өрхөөр өссөн байна.

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

хүснэгт 9

	2014	2015	2016	2017	2017 он				
					Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Бүгд	271	293	321	356	19	13	4	82	238
10 хүртэл малтай	7	7	7	7	1	1	2	1	2
11-30 малтай	21	21	21	21	1	2	2	4	13
31-50 малтай	41	41	41	41	2	2	1	8	27
51-100 малтай	73	73	74	74	5	4	2	16	47
101-200 малтай	148	148	149	147	10	6	2	30	99
201-500 малтай	327	330	332	333	19	12	3	66	232
501-999 малтай	652	656	663	677	32	23	6	158	458
1000-1499 малтай	1119	1115	1128	1137	57	44	10	307	720
1500-2000 малтай	1618	1639	1651	1666	123	78	31	548	887
2001-ээс дээш малтай	2164	2191	2232	2215	87	71	10	695	1353

Эх сурвалж: 2014-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Аймгийн дунджаар нэг малтай өрхөд 356 мал оногдож байгаа нь 2016 оноос 35 толгой малаар өссөн байна. Малтай нэг өрхөд 19 тэмээ, 13 адуу, 4 үхэр, 82 хонь, 238 ямаа ногдож байна.

2.4 Хээлтэгч мал.

2017 онд 1066.1 мянган толгой хээлтэгч тоологдсон нь өмнөх оноос 10.7 хувиар буюу 102.9 мянган толгойгоор өссөн байна. Энэ онд Ингэ 8.1 хувиар, гүү 14.8 хувиар, үнээ 17.6 хувиар, Эм хонь 14.8 хувиар, Эм ямаа 9.2 хувиар тус тус өсчээ.

Хээлтэгч малын тоо


мян.толгой	2011	2012	2013	2014	2015	2016	2017	хүснэгт 10	
								2017/2016	
								хувь	зөрүү
Ингэ	30.1	33.3	35.4	37.5	39.7	44	47.6	108.1	3.6
Гүү	13.7	15.1	17	20.2	23.2	27.3	31.3	114.8	4.0
Үнээ	3.8	4.2	5.2	6.4	7.6	8.9	10.5	117.6	1.6
Эм хонь	102.4	126.2	145.2	172	191.4	220.5	253.1	114.8	32.6
Эм ямаа	327.4	396.4	458.1	540.3	583.6	662.4	723.6	109.2	61.2
Дүн	477.4	575.2	660.8	776.4	845.5	963.2	1066.1	110.7	102.9

Эх сурвалж: 2011-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээлтэгч мал нь нийт малын 40.2 хувийг эзлэж байгаа бөгөөд тэмээн сүргийн 33.7 хувийг, адуун сүргийн 31.8 хувийг, үхэр сүргийн 38.8 хувийг, хонин сүргийн 41.2 хувийг, ямаан сүргийн 40.8 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч
/төрлөөр ,хувь/


Зураг 8



Нийт хээлтэгчийн 4.0 хувийг ингэ, 3.0 хувийг гүү, 1.0 хувийг үнээ, эм хонь 24.0 хувь, эм ямаа 68.0 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч малын тоо /2003-2017 он/

Зураг 9



Сүүлийн жилүүдэд хээлтэгч малын тоо тогтмол өсч байсан боловч 2010, 2011 онуудад буурч, 2012 оноос өсөх хандлагатай болсон байна.

2.5 Төл бойжилт .

2017 онд гарсан төлийн 99.1 хувь нь буюу 664.3 мянган төл бойжуулсан байна.. Бойжсон төлийн тоо 2016 оныхоос 123.8 мянган толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 99.6 хувь, унаганы 99.0 хувь, тугалны 99.3 хувь, хурганы 98.9 хувь, ишигний 99.7 хувийг бойжуулсан байна.

Төл бойжилт

хүснэгт 11

	2013	2014	2015	2016	2017	Үүнээс					2017/ 2016 хувь
						ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	472665	457018	540719	543751	670614	20463	17998	6283	180638	445232	123.3
Бойжсон	469222	450151	530741	540484	664257	20383	17825	6242	179607	440200	122.9
Хорогдсон	3443	6867	9978	3267	6357	80	173	41	1031	5032	194.6
Бойжилтын хувь	98.8	98.5	98.2	99.4	99.1	99.6	99	99.3	99.4	98.9	99.7

Эх сурвалж: 2013-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2017 онд аймгийн дунджаар 100 эхээс 69 төл бойжуулсан байна. Энэ онд 100 эхээс бойжуулсан төл нь урьд оноос гүү, үнээ, эм хонь, эм ямааны бойжуулсан төл өсч, ингэнээс бойжуулсан төл буурсан байна.

100 эхээс бойжуулсан төл

хүснэгт 12

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016
Бүгд	86	90	75	8	78	82	82	68	68	64	69	107.8
Ингэ	48	56	50	45	45	59	45	55	44	54	46	85.2
Гүү	74	82	69	13	76	74	81	67	65	61	65	106.6
Үнээ	75	87	76	25	74	80	87	74	69	65	70	107.7
Эм хонь	91	95	85	11	87	89	90	80	77	79	81	102.5
Эм ямаа	88	91	73	5	44	83	82	65	67	60	66	110.0

Эх сурвалж: 2007-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2.6 Том малын зүй бусын хорогдол.

2017 онд оны эхний малын 0.48 хувь нь буюу 11.3 мянган толгой мал хорогдсон нь 2016 оноос 1163 толгой малаар буюу 11.5 хувиар өссөн байна. Нийт хорогдсон малын 73.9 хувийг ямаа сүрэг, 21.9 хувийг хонин сүрэг, 1.9 хувийг адуу сүрэг, 1.7 хувийг тэмээ сүрэг, 0.7 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол


хүснэгт 13

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	Зөрүү
Бүгд	618766	9399	8815	9727	11128	17326	10089	11251	111.5	1162
Тэмээ	7027	462	288	364	354	481	244	190	77.9	-54
Адуу	13033	336	215	196	402	582	228	211	92.5	-17
Үхэр	5269	99	57	49	90	109	129	74	57.4	-55
Хонь	135864	2232	2179	2454	2406	2667	2310	2463	106.6	153
Ямаа	457573	6270	6076	6664	7876	13487	7178	8313	115.8	1135

Эх сурвалж: 2010-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зүй бус хорогдол /2008-2016 он/

Зураг 10



2.7 Малын хээл хаялт, сувайралт.

2017 онд оны эхний хээлтэгч малын 0.2 хувь нь буюу 2306 толгой хээлтэгч хээл хаяж, 28.7 хувьтай тэнцэх 276.3 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 278.6 мянгад хүрч түүний 99.2 хувийг сувайрсан хээлтэгч, 0.8 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна.

Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо

хүснэгт 14

	Хээл хаясан хээлтэгч						Сувайрсан хээлтэгч					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	978	846	2241	2304	5370	2306	79705	93158	183799	206988	278868	276346
Ингэ	21	3	3	79	13	9	439	280	535	294	496	580
Гүү	17	26	37	81	130	167	3288	2802	5484	6480	8584	9597
Үнээ	1	2	10	20	19	65	776	672	1457	1970	2551	2743
Эм хонь	79	79	372	319	309	178	14470	16239	27969	37856	42666	45901
Эм ямаа	860	736	1819	1805	4899	1887	60732	73165	148354	160388	224571	217525

Эх сурвалж: 2012-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээл хаясан хээлтэгч өмнөх онтой харьцуулахад 57.1 хувиар, сувайрсан хээлтэгч 0.9 хувиар тус тус буурсан байна.

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь


хүснэгт 15

	Хээл хаясан хээлтэгч						Сувайрсан хээлтэгч					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	0.2	0.1	0.3	0.3	0.6	0.2	16.7	16.2	23.7	24	33	28.7
Ингэ	0.1	0	0	0.2	0	0.0	1.5	0.8	1.4	1	1.2	1.3
Гүү	0.1	0.2	0.2	0.3	0.6	0.6	24	18.5	27.2	28	37	35.1
Үнээ	0	0	0.2	0.3	0.3	0.7	20.2	15.9	22.9	26	33.7	30.8
Эм хонь	0.1	0.1	0.2	0.2	0.2	0.1	14.1	12.9	16.3	20	22.3	20.8
Эм ямаа	0.3	0.2	0.3	0.3	0.8	0.3	18.6	18.5	27.5	27	38.5	32.8

Эх сурвалж: 2012-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээл хаялт, сувайралт

Зураг 11



2.8. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь малын бүх төрөл дээр алдагдсан хэвээр байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.

2017 онд 17.2 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2016 оноос 7.9 хувь буюу 1271 толгойгоор өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч малын 5 н төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна.

Хээлтүүлэгч малын тоо

хүснэгт 16

	Хээлтүүлэгч мал						
	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	10255	11637	12382	13375	14400	15971	17242
Буур	961	1000	1027	1070	1111	1226	1275
Азарга	2226	2379	2594	2887	3248	3667	4044
Бух	194	205	251	293	357	429	459
Хуц	2708	2977	3111	3359	3628	4121	4430
Ухна	4166	5076	5399	5766	6056	6528	7034

Эх сурвалж: 2011-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 37, адуун сүргийн хувьд 12-15 байхад 8, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 23 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 57, ямаанд 103 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа өмнөх онтой харьцуулахад тэмээн сүрэг 1 хээлтэгчээр, адуун сүрэг 1 хээлтэгчээр, үхэр сүрэг 2 хээлтэгчээр, хонин сүрэг 3 хээлтэгчээр, ямаан сүрэг 2 хээлтэгчээр тус тус нэмэгдсэн байна.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

хүснэгт 17

хуц	Үржлийн норм	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Буур	20-25*	31	33	34	35	36	36	37
Азарга	12-15.*	6	6	7	7	7	7	8
Бух	35-45*	20	21	21	22	21	21	23
Хуц	25-30*	38	42	47	51	53	54	57
Ухна	25-30*	79	78	85	94	96	101	103

Эх сурвалж: 2011-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

*-нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо.

2.9 Малын хэрэглээний зарлага.

2017 онд аймгийн хэмжээнд оны эхний малын 13.5 хувь буюу 312.6 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2016 оноос 40.4 мянган толгой малаар өссөн байна. Малтай нэг өрх дунджаар жилд 34 мал үүнээс 1.3 тэмээ, 0.6 адуу, 0.2 үхэр, 11.7 хонь, 29.8 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 15 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага

хүснэгт 18

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	389.4	182.5	184.2	189.1	225.4	243.2	306.7	272.2	312.6
Тэмээ	8.1	7.7	8.1	8.1	8.8	9.6	10.2	9.3	9.5
Адуу	8.5	4.9	2.9	3.2	4	2.8	4.8	2.8	4.3
Үхэр	2.6	1.5	1.1	1	1	1.1	1.7	1.3	1.3
Хонь	90.8	44.1	52.4	46.7	59.6	67.3	80.3	75.8	84.1
Ямаа	279.2	124.3	119.6	130.1	152	162.4	209.7	182.9	213.5

Эх сурвалж: 2009-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Оны эхний малд эзлэх хувь

хүснэгт 19


	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	23.1	10.4	18.2	15.4	15.9	14.7	16.6	13.2	13.5
Тэмээ	10.1	9	9.7	9.2	9	9.3	9	7.8	7.2
Адуу	16.1	9.1	7.7	7.3	8	4.8	7.2	3.8	5.0
Үхэр	21.1	11.5	15.2	11.4	9.4	7.8	10.7	7	6.0
Хонь	25.9	11.7	24.6	18.1	19.9	19.1	20.2	17	16.1
Ямаа	23.5	10.1	17.9	15.7	15.8	14.4	16.7	13.1	13.7

Эх сурвалж: 2009-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт хэрэглээнд зарцуулсан малын 95.0 хувийг бог мал, 5.0 хувийг бод мал эзэлж байна.

Малын хэрэглээний зарлага /төрлөөр/

Зураг 12



Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн

дотоодод хэрэглэсэн малын тоо

хүснэгт 20

	Зах зээлд худалдан борлуулсан						Аж ахуйн дотоодод хэрэглэсэн					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	67047	76193	85173	95525	104851	143414	188493	119693	129339	141479	145882	180797
Тэмээ	4487	4530	5429	4753	3549	6145	3159	2955	3198	3289	2935	3911
Адуу	2016	2385	2942	3021	1148	5359	2114	2145	2314	2765	1432	3605
Үхэр	502	618	777	952	5294	1660	769	899	1029	1217	3424	1836
Хонь	16702	19745	23342	25950	29478	39878	31334	34003	37914	40100	42795	51783
Ямаа	43340	48915	52683	60849	65382	90372	75517	79691	84884	94108	95296	119662

Эх сурвалж: 2012-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2017 онд зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 44.2 хувийг зах зээлд борлуулж, 55.8 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 20 толгой малыг зах зээлд борлуулж, 25 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

2.10 Сүргийн бүтэц.

2017 онд нийт сүргийн 25.0 хувь нь буюу 664.3 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 34.2 хувь буюу 906.8 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 40.2 хувь буюу 1066.1 мянган толгой хээлтэгч, 0.6 хувь буюу 17.2 мянган толгой хээлтүүлэгч гэсэн бүтэцтэй байна.

2017 оны сүргийн бүтэц

хүснэгт 21

	Толгойгоор					Нийт сүрэгт эзлэх хувь				
	Бүгд	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч
Бүгд	2654388	664257	906825	1066064	17242	100.0	25.0	34.2	40.2	0.6
Тэмээ	141232	20383	71996	47578	1275	100.0	14.4	51.0	33.7	0.9
Адуу	98651	17825	45440	31342	4044	100.0	18.1	46.1	31.8	4.1
Үхэр	26997	6242	9830	10466	459	100.0	23.1	36.4	38.8	1.7
Хонь	613980	179607	176855	253088	4430	100.0	29.3	28.8	41.2	0.7
Ямаа	1773528	440200	602704	723590	7034	100.0	24.8	34.0	40.8	0.4

Эх сурвалж: 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Сүргийн бүтэц нийт сүрэгт эзлэх хувь

Зураг 13



3.Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

3.1 Бэлчээрийн хүрэлцээ.

Газрын албаны 2017 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээрийн талбай 10.3 сая га талбайд хүрч малын тоо хонин толгойд шилжүүлснээр 3.8 сая толгойд хүрсэн байна. 2017 онд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 37 толгой мал ногдож байна.

Бэлчээрийн хүрэлцээ

хүснэгт 23

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/ 2016
Бэлчээрийн талбай /мян.га/	11455.5	11426.1	11372.2	11372.2	11363.8	11358.7	11357.8	11072.3	10302.1	93.0
Хонин толгойд шилжүүлсэнээр 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо	21	13	16	18	21	23	26	30	37	123.0

Эх сурвалж: 2009-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зураг 14



Манай аймгийн хувьд бэлчээрийн талбай их байгаа хэдий ч ус худгийн хүрэлцээ хангамж муу, мөн малчдын суурьшил ихтэй газруудад ашигт малтмалын болон хайгуулын лицензтэй ААНэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаагаас малын бэлчээрийн хүрэлцээ багасаж байна.

3.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт.


2017 онд аймгийн хэмжээгээр 5626.6 тонн хадлан, 17.7 тонн таримал тэжээл , 1009.9 тонн гар тэжээл, 49.1 тонн даршны ургамал, 3888.8 тонн хужир шүү, 38.9 тонн төмс, ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.

Өөрийн хүчээр бэлтгэсэн хадлан нэр, төрлөөр

хүснэгт 24

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016
Хадлан өвс	3081.1	3561.1	4909.7	4265.8	9625.9	5360	6844.2	5626.6	82.2
Таримал тэжээл	266.6	31.9	17.9	28.5	36.6	247.5	57.2	17.7	30.9
Даршны ургамал	9.4	6.66	37.5	16.4	14.5	13.2	827.5	49.1	5.9
Гар тэжээл	518.3	439.9	803.3	519.5	726.5	1838.5	2598.3	1009.9	38.9
Хужир шүү	1337.5	1937.9	801.6	1329.6	2771.6	4734.1	6189.6	3888.8	62.8
Төмс ногооны хаягдал	59.6	51.1	83.6	46.7	81.8	20.5	16.9	38.9	230.2
Үр тарианы хаягдал			2	3.1	1.3	17	0	25.8	
Сүрэл	75.1		6	0.06	0.5	10.5	10.1	14.1	139.6

Эх сурвалж: 2010-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн



Зураг 15

3.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

хүснэгт 25

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016
Бүгд	5272.5	6028.56	6659.69	6209.66	13258.7	12245.5	16543.8	10670.9	64.5
Хүчит	266.6	31.9	17.9	31.6	37.9	264.5	57.2	25.8	45.1
Шүүст	69	57.8	121.1	63.1	96.3	33.7	844.4	88	10.4
Бүдүүн	3599.4	4001	5719.1	4785.4	10352.9	7213.2	9452.6	6650.6	70.4
Бусад	1337.5	1937.9	801.6	1329.6	2771.6	4734.1	6189.6	3906.5	63.1
Хонин тодгойд шилжүүлсэн 1 мал ногдох тэжээл тэж.кг	1.7	3.4	3.3	3.3	4.9	4.2	7.1	2.8	39.4

Эх сурвалж: 2010-2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг тооцлоо. Тэжээл бүрээр тодорхой итгэлцүүр ашиглан тэжээлийн нэгжид шилжүүллээ.

Дүгнэлт

2017 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7418 малтай өрх, үүнээс 5819 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 34.8 хувийг малтай өрх эзэлж байна.

Мал аж ахуйн салбарт 9635 малчид ажиллаж байна. Нийт малчдын 44.8 хувь нь буюу 4315 эмэгтэйчүүд байна.

Нийт малчин өрхийн 78.3 хувь буюу 4559 өрх цахилгааны эх үүсвэртэй, 74.2 хувь буюу 4318 өрх телевизортой, 47.9 хувь буюу 2788 өрх автомашинтай, 49.7 хувь буюу 2892 өрх мотоциклтой, 0.2 хувь буюу 14 өрх трактортой байна.

Өмнөговь аймгийн 15 сумын 58 багт 2.6 сая толгой мал тоолуулж 2016 оныхоос 340.4 мянган толгой малаар буюу 14.7 хувиар өссөн байна. Мал сүрэг таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна. Тооллогын дүнгээр тэмээний тоо 141232 толгой, адуу 98651 толгой, үхэр 26997 толгой, хонь 613980 толгойд, ямаа 1773528 толгойд хүрсэн байна. Өмнөх оныхоос тэмээ 10739 толгойгоор буюу 8.2 хувиар, адуу 13353 толгойгоор 15.7 хувиар, үхэр 4848 толгойгоор буюу 21.9 хувиар, хонь 93075 толгойгоор 17.9 хувиар, ямаа 218410 толгойгоор буюу 14.0 хувиар тус тус өссөн байна. Нийт мал сүрэг өмнөх онтой харьцуулахад 5.6-27.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт мал сүрэг өмнөх мөн үеэс 14.7 хувиар өсчээ.

Малын өсөлтөнд нөлөөлдөг гол хүчин зүйл болох бойжсон төлийн тоо өмнөх оноос 123.7 мянган төлөөр өсч, том малын зүй бусын хорогдол өмнөх оноос 1162 малаар буюу 11.5 хувиар, хээлтэгч малын тоо 10.7 хувиар өссөн, сувайрсан хээлтэгч өмнөх оноос 57.1 хувиар, хээл хаясан хээлтэгч 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бойжуулсан төл 664.3 мянгад хүрсэн нь өмнөх оны мал тооллогын дүнгээс 123.8 мянган төлөөр буюу 22.9 хувиар буурсан өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

Хээлтэгч малын тоо нь 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1066.1 мянгад хүрсэн нь өмнөх мөн үеэс 102.9 мянгаар буюу 10.7 хувиар өссөн байна.

2017 онд хувийн малын тоо 2642.4 мянган толгойд хүрч, нийт малын 99.6 хувийг эзэлж байна. Тэмээн сүргийн 99.3 хувь, адуун сүргийн 99.8 хувь, үхэр сүргийн 99.5 хувь, хонин сүргийн 99.4 хувь, ямаан сүргийн 99.6 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо өмнөх оноос 341.5 мянган толгой буюу 14.9 хувиар өссөн байна. Хувийн аж ахуйн нийт малын 66.9 хувийг ямаа, 23.1 хувийг хонь, 5.3 хувийг тэмээ, 3.7 хувийг адуу, 1.0 хувийг үхэр эзэлж байна.

Нийт өрхийн 1.2 хувийг 10 хүртэл малтай өрх, 5.4 хувийг 11-30 малтай өрх, 6.1 хувийг 31-50 малтай өрх, 12.8 хувийг 51-100 малтай өрх, 16.3 хувийг 101-200 малтай өрх, 32.3 хувийг 201-500 малтай өрх, 19.1 хувийг 501-999 малтай өрх, 6.0 хувийг 1000-1499 малтай өрх, 0.5 хувийг 1500-2000 малтай өрх, үлдсэн 0.2 хувийг 2000 –с дээш малтай өрх эзэлж байна. 1000 ба түүнээс дээш малтай 501 өрх тоологдсон нь өнгөрсөн оноос 125 өрхөөр өссөн байна.

Аймгийн дунджаар нэг малтай өрхөд 356 мал оногдож байгаа нь 2016 оноос 35 толгой малаар өссөн байна. Малтай нэг өрхөд 19 тэмээ, 13 адуу, 4 үхэр, 82 хонь, 238 ямаа ногдож байна.

Гарсан төлийн 99.1 хувь нь буюу 664.3 мянган төл бойжуулсан байна. Бойжсон төлийн тоо 2016 оныхоос 123.8 мянган толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 99.6 хувь, унаганы 99.0 хувь, тугалны 99.3 хувь, хурганы 98.9 хувь, ишигний 99.7 хувийг бойжуулсан байна. Аймгийн дунджаар 100 эхээс 69 төл бойжуулсан байна. Энэ онд

100 эхээс бойжуулсан төл нь урьд оноос гүү, үнээ, эм хонь, эм ямааны бойжуулсан төл өсч, ингэнээс бойжуулсан төл буурсан байна.

2017 онд оны эхний малын 0.48 хувь нь буюу 11.3 мянган толгой мал хорогдсон нь 2016 оноос 1163 толгой малаар буюу 11.5 хувиар өссөн байна. Нийт хорогдсон малын 73.9 хувийг ямаа сүрэг, 21.9 хувийг хонин сүрэг, 1.9 хувийг адуу сүрэг, 1.7 хувийг тэмээ сүрэг, 0.7 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна.

Оны эхний хээлтэгч малын 0.2 хувь нь буюу 2306 толгой хээлтэгч хээл хаяж, 28.7 хувьтай тэнцэх 276.3 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 278.6 мянгад хүрч түүний 99.2 хувийг сувайрсан хээлтэгч, 0.8 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь малын бүх төрөл дээр алдагдсан хэвээр байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.

2017 онд 17.2 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2016 оноос 7.9 хувь буюу 1271 толгойгоор өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч малын 5 н төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна.

Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 37, адуун сүргийн хувьд 12-15 байхад 8, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 23 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 57, ямаанд 103 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа өмнөх онтой харьцуулахад тэмээн сүрэг 1 хээлтэгчээр, адуун сүрэг 1 хээлтэгчээр, үхэр сүрэг 2 хээлтэгчээр, хонин сүрэг 3 хээлтэгчээр, ямаан сүрэг 2 хээлтэгчээр тус тус нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд оны эхний малын 13.5 хувь буюу 312.6 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага 2016 оноос 40.4 мянган толгой малаар өссөн байна. Малтай нэг өрх дунджаар жилд 34 мал үүнээс 1.3 тэмээ, 0.6 адуу, 0.2 үхэр, 11.7 хонь, 29.8 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 15 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 44.2 хувийг зах зээлд борлуулж, 55.8 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 20 толгой малыг зах зээлд борлуулж, 25 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

2017 онд нийт сүргийн 25.0 хувь нь буюу 664.3 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 34.2 хувь буюу 906.8 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 40.2 хувь буюу 1066.1 мянган толгой хээлтэгч, 0.6 хувь буюу 17.2 мянган толгой хээлтүүлэгч гэсэн бүтэцтэй байна.

Мал аж ахуйн салбарын өсөлтөд байгаль цаг уурын таатай нөхцөл ихээхэн нөлөөлж байгаа боловч үүний зэрэгцээ малын гаралтай түүхий эдийн үнийн өсөлт нөлөөлсөн байна. Үүний хажуугаар мал эмнэлгийн үйлчилгээ орхигдож, удмын сан сүргийн бүтцийн харьцаа алдагдаж, өндөр ашиг шим өгдөг цэвэр эрлийз үүлдрийн малын тоо цөөрсөн, малын чанар муудсан зэрэг хүндрэлтэй асуудлууд байна.

Өдгөө мал сүрэг маань эргээд эрчимтэй өсч үржиж байгаа бөгөөд бэлчээрийн мал аж ахуйг цаашид хөгжүүлэхдээ бэлчээрийн даац, сүргийн бүтцээ зөв тохируулан, чанаржуулж өсгөх бодлогыг баримтлах хэрэгтэй байна.

Манай аймаг байгаль цаг агаар, газар нутгийн хувьд бусад аймгуудаас харьцангуй өвөрмөц онцлогтой бөгөөд ХАА-н салбар нь нийтдээ байгалиас шууд хамааралтай, эрчимжсэн аж ахуйн хөгжил сул байгаа зэрэг нь энэ салбарын цаашдын хөгжлийн талаар бодлого төлөвлөгөөтэй ажиллах

зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Түүнчлэн ажилгүйдэл ядуурлын түвшинг байнга хэлбэлзүүлж байдаг энэ салбарт зах зээлийн өнөөгийн нийгэмд зохицсон бодлого хөтөлбөр гарган системтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

2017 онд аймгийн хэмжээгээр 5626.6 тонн хадлан, 17.7 тонн таримал тэжээл , 1009.9 тонн гар тэжээл, 49.1 тонн даршны ургамал, 3888.8 тонн хужир шүү, 38.9 тонн төмс, ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.

Сүүлийн 10 жил тус аймгийн газар тариалангийн салбар өсөлт бууралттай явж ирсэн бөгөөд тариалалт, хураан авсан ургац буурч байгаа нь усан хангамжийн хүрэлцээ дутмаг, болсны дээр удирдлага менежменттэй холбоотой асуудлууд нилээдгүй байна.

Боловсруулсан

мэргэжилтэн:

С.Цэвэлмаа

Хянасан

**Статистикийн
хэлтсийн дарга:**

С.Бямбабаатар

Харилцах утас: 70533061, 70533439

E-mail хаяг: umnugobi_stat@yahoo.com
<http://www.umnugovi.nso.mn>

2018 оны 06 сарын 10